



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 8416

Улаанбаатар хот


Г Түр заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн бус орчинд коронавируст халдварт (КОВИД-19)-тай иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлэхэд баримтлах түр заавар”-ыг хавсралтаар баталсугай.
2. Шаардлагын дагуу сонгон шалгаруулалт хийх, аймаг, нийслэлийн Онцгой комиссоор шийдвэрлүүлэх, эмнэлгийн бус орчинд дэлгэсэн орны, бэлэн байдлыг хангах, харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгуулагатай уялдаа, холбоотой ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга наарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Буяントогтох/-т, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж хүний нөөцийн дэмжлэг үзүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус даалгасугай.
4. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн тохиолдлыг эмнэлгийн бус орчинд ор дэлгэн эмчлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж дэмжин ажиллахыг Эмнэлзүйн зөвлөх баг, Халдварт өвчин судлалын үндэсний төв (Л.Баттөр)-д, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар /Б.Цэцэгсайхан/-т, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, тусгаарлан эмчлэх байрыг хариуцан ажиллах эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал наарт даалгасугай.
5. Коронавируст халварын голомтын ариутгал, халварын сэргийлэлтийг хангахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Л.Энхсайхан/-т, Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Н.Цогбадрах/-д тус тус даалгасугай.

6. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тусгаарлан эмчлэхтэй холбоотой зардлыг зохих тушаал, журмын дагуу хянаж Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т даалгасугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ц.Эрдэмбилэг)-д үүрэг болгосугай.



**ЭМНЭЛГИЙН БУС ОРЧИНД КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ТАЙ
ИРГЭДЭД ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ТҮР ЗААВАР**

Нэг: Үндэслэл

1.1. Тусгаарлан эмчлэх нь халдварт өвчний тархалтыг хязгаарлах нийгмийн эрүүл мэндийн цогц хариу арга хэмжээний бурэлдэхүүн хэсэг бөгөөд 2005 онд батлагдсан Олон улсын эрүүл мэндийн дүрмийн 3 дугаар зүйл, 2021 онд гаргасан ДЭМБ-аас “Коронавируст халдварт (КОВИД-19)-ын хөнгөн тохиолдлыг тусгаарлан тусlamж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн бус байгууллагуудын зохион байгуулалт” зөвлөмжийг үндэслэн боловсруулсан болно.

1.2. Энэхүү журмаар коронавируст халдварт (КОВИД-19)-тай иргэдийг эмнэлгийн бус орчинд дэлгэсэн тусгаарлан эмчлэх байранд (цаашид тусгаарлан эмчлэх байр-ТЭБ гэх) тусlamж, үйлчилгээ үзүүлэх асуудлыг зохицуулна.

1.3. Тусгаарлан эмчлэх байрны үйл ажиллагаанд шаардагдах холбогдох зардлыг Эрүүл мэнд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 67/ А/268 дугаар тушаалын дагуу санхүүжүүлнэ.

Хоёр. ТЭБ-д хэвтүүлэх заалт

- 2.1. Коронавируст халдварт (КОВИД-19)-тай эмнэлзүйн хувьд хөнгөн ч эрсдэлтэй гэж үнэлэгдсэн иргэн
- 2.2. Коронавируст халдварт (КОВИД-19)-тай эмнэлзүйн хувьд 'хөнгөн, эрсдэл багатай гэж үнэлэгдсэн ч гэрт тусгаарлагдан эмчлэгдэх боломжгүй иргэн
 - тусгаарлах өрөөний боломжгүй,
 - тусдаа унтлагын өрөө, ариун цэврийн өрөөгүй,
 - тусгаарлах эд хэрэгсэл, хоол хүнсний хэрэгсэлгүй айл өрхийн гишүүн,
 - орон гэргүй иргэн,
- 2.3. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг авахад хязгаарлагдмал (утас, интернет, зам) алслагдсан газар амьдардаг айл өрхийн гишүүн;

Гурав. Ор дэлгэх байгууллагуудыг сонгох

- 3.1. ТЭБ-ыг сонгох, бэлэн байдлыг хангуулахыг аймаг, дүүргийн онцгой комисс эрүүл мэндийн байгуулагатай зөвшилцэн сонгоно.
- 3.2. Коронавируст халдварт (КОВИД-19)-тай иргэдийг ТЭБ-ыг дараах эрэмбийн дагуу дэлгэн бэлэн байдлыг ханган ажиллуулна. Үүнд:
 - 3.1.1. Зочид буудал
 - 3.1.2. Амралтын газар
 - 3.1.3. Оюутны дотуур байр
 - 3.1.4. Спорт заал
 - 3.1.5. Хээрийн эмнэлэг
- 3.3. ТЭБ-ыг аймаг, дүүрэг, нийслэлийн онцгой комисст танилцуулсан байна.
- 3.4. Аймаг, дүүргийн онцгой комиссоос салбар дундын хамтарсан баг (эрүүл мэнд, мэргэжлийн хяналт, онцгой гэх мэт) ажиллуулан, гаргасан дүгнэлтийг үндэслэн ТЭБ-ны үйл ажиллагааг эхлүүлнэ.

3.5. ТЭБ-ыг орон нутгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангана.

3.6. ТЭБ-д хэвтэх иргэнийг аймаг, дүүргийн хариу арга хэмжээний баг тээвэрлэнэ.

Дөрөв. ТЭБ-нд тавигдах шаардлага

4.1. Тусlamж, үйлчилгээ үзүүлэх, тоног төхөөрөмж байршуулах, яаралтай засвар үйлчилгээ хийх боломжтой, зай талбай сайтай байна.

4.2. Яаралтай тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд талбай чөлөөлөх боломжтой байна.

4.3. Өвчтөний орох, гарах урсгалыг зохион байгуулах боломжтой, 3-4 орох гарах хаалгатай байна.

4.4. Нэг өвчтөнд ноогдох талбай 4-7 м² байна.

4.5. Өвчтөний ор хоорондын зайд 1 метр байх боломжтой байна.

4.6. Эмнэлгийн ажилтанд зориулсан ариун цэврийн өрөөтэй байна.

4.7. Улаан, шар, ногоон бүс зохион байгуулах боломжтой байна.

4.8. Хамгийн багадаа 20 өвчтөн тутамд 1 угаалтуур, 1 суултуур оногдох боломжтой байна.

4.9. Замын дэд бүтэц, аюулгүй байдал, харилцаа холбоог хангасан газар байрладаг байна.

4.10. Шал нь тэгш, угааж цэвэрлэхэд хялбар байх, хальтарч унахаас сэргийлсэн байна.

4.11. Цэвэр, аюулгүй ундны ус болон ариун цэврийн байгууламжийг ашиглахад хүртээмжтэй байна.

4.12. Цахилгаан, дулаан, усан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн болон хэсгийн системд холбогдсон байна.

4.13. Тэргэнцэртэй болон дамнуургатай өвчтөн зөөвөрлөх боломжтой байна.

4.14. Нэгдсэн хоол үйлдвэрлэл ажиллуулах боломжтой байх, боломжгүй тохиолдолд хоол үйлдвэрлэлийн мэргэжлийн байгуулагатай гэрээ хийсэн байна.

4.15. Үйлчлүүлэгчийг зөөвөрлөхөд саадгүй цахилгаан шат, түргэн тусlamжийн машин орж гарах боломжтой машины зогсоолтой байна.

4.16. Ундны усны хэсгийн системд холбогдсон бол харьяалах нутаг дэвсгэр дэх мэргэжлийн хяналтын байгууллагаар ундны усны эх үүсвэр, хэрэглээний шугамын усанд нян судлалын шинжилгээг хийлгэж, дүгнэлт гаргуулсан байна.

4.17. Гадуурхал, хүчирхийллээс хамгаалах орчин бүрдүүлнэ.

4.18. Олон давхар барилгууд, тухайлбал зочид буудал, дотуур байранд өвчтөн болон ажилтнуудад зориулсан шат, цахилгаан шатыг тусад нь зохион байгуулсан байна.

4.19. Үйлчлүүлэгчийн хувийн нууцлалыг хангах, хамгаалахын тулд эмнэлгийн өрөө, тасагтай адил өвчтөн хооронд тусгаарлалт хийх. Хэрэв боломжтой бол, нэг давхарт эрэгтэй, эмэгтэй өвчтөнүүдийг тус тусдаа хэсэгт байрлуулах, эсвэл тусдаа өөр өөр давхарт байрлуулах, хувийн эрүүл ахуйн нөхцлийг хангахад нь зориулж тусдаа ариун цэврийн өрөө, хэрэгслээр хангасан байна.

Тав. ТЭБ-ын эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж

5.1. Эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан нэн шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлэх. Үүнд:

5.1.1. Цэвэр дүрэмт хувцас

5.1.2. Нэг удаагийн халад

5.1.3. Эмнэлгийн маск

- 5.1.4. Нүдний хамгаалалт
 - 5.1.5. Бээлий
- 5.2. Эрүүл мэндийн бус ажилтнуудад зориулсан нэн шаардлагатай хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөц бүрдүүлэх. Үүнд:
 - 5.2.1. Бээлий
 - 5.2.2. Нэг удаагийн халад
 - 5.2.3. Битүү гутал
 - 5.2.4. Хэрэв үйл ажиллагааны явцад ус цацагддаг бол (тухайлбал, гадаргууг угаах үед) нэмэлт хамгаалах хэрэгслүүд буюу нүүрний хамгаалалт, ус нэвтрүүлдэггүй хормочоор хангах.
- 5.3. Үндсэн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслүүд:
 - 5.3.1. Үйлчлүүлэгчийн амин үзүүлэлтийг хянах хяналтын монитор
 - 5.3.2. Соруулах аппарат /отсос амны хөндийн цэр салст соруулах/
 - 5.3.3. Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат
 - 5.3.4. Хүчилтөрөгч өтгөрүүлэгч /хамрын ац гуурс, маск, нөөц уут/
 - 5.3.5. Зөөврийн баллонтой хүчилтөрөгч, редуктор
 - 5.3.6. Дефебрилятор
 - 5.3.7. Пульсоксиметр
 - 5.3.8. Хэл дарагч
 - 5.3.9. Үзлэгийн болон яаралтай тусламжид шаардлагатай хэрэгслүүд (даралтны аппарат, чагнуур, биеийн халуун хэмжигч, хошуувч № 3,4 амбу, интубацийн хэрэгсэл №6-8 хэмжээтэй интубацийн гуурс, хийлэгч, ларингоскопи 3 хошуутай, яаралтай тусламжийн эм тариа гэх мэт)
 - 5.3.10. Дамнуурга, тэргэнцэр
 - 5.3.11. Зөөврийн рентген
- 5.4. Нэмэлтээр дараах хэрэгслүүдээр хангаж, холбогдох арга хэмжээг авсан байвал зохино.
 - 5.4.1. Тухайн нөхцөлд тохирсон стресс бууруулах, тайвшруулах, дасгал хөдөлгөөн хийх, дэмжлэг үзүүлэх арга хэрэгслээр /тухайлбал, ном, телевизор, хүүхдийн тоглоом зэргээр/ хангах;
 - 5.4.2. Хэрэгслүүдийг дундаа хэрэглэх бол халдварын сэргийлэлт, хяналтыг маш сайн мөрдүүлэх;
 - 5.4.3. Ялаа, шумуулнаас хамгаалах тор болон шавж устгалыг хийх.

Зургаа. ТЭБ-ны халдварын сэргийлэлт, хяналт, аюулгүй ажиллагаа

- 7.1. Харьяалах эрүүл мэндийн байгууллага нь халдварын сэргийлэлт, хяналтын мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж ажиллана.
- 7.2. Халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр гарсан тушаал шийдвэрийг мөрдөж ажиллана.
- 7.3. Эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан нэн шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлсэн байна.
- 7.4. Тусгаарлан эмчлэх байрны халдвартгүйтгэл, цэвэрлэгээг холбогдох заавар, журмын дагуу хийж гүйцэтгэнэ.
- 7.5. Аюулгүй ажиллагааны дагуу эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгсэл, угаалга, гал тогооны хэрэгслийн ашиглалтыг зохицуулах ба эмнэлгийн хог хаягдлыг аюулгүй хадгалах, зайлуулах, устгах арга хэмжээний зохицуулалтыг тухай бүрт нь хийнэ.
- 7.6. Хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх, устгах журмыг мөрдөж

ажиллана.

Долоо. ТЭБ-ны хүний нөөц

7.1. Мэргэшсэн хүний нөөц

7.1.1. ТЭБ-д ажиллах эмч, мэргэжилтнүүдийг удирдах ахлагчийг сонгоно.

Ахлагч нь багийг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

7.1.2. Тусlamж үйлчилгээнд мэргэжлийн баг, хүний нөөцийг бурдуулж ажиллах багийн бүрэлдэхүүн, ажлын хуваарьтай байна.

7.1.3. Ээлж бүрийн ажлын эхлэл, төгсгөлд ажилтнуудын бүртгэлийг хийсэн байна.

7.1.4. Эрүүл мэндийн ажилтнуудыг үйлчлүүлэгчийн биеийн байдлыг тогтмол хянах нөхцлөөр хангасан байна.

7.1.5. Эрүүл мэндийн ажилтнуудыг сэтгэл зүйгээр дэмжих, стресс тайлах дэмжлэгт нөхцлөөр хангасан байна.

7.1.6. Эрүүл мэндийн болон бусад ажилчдыг коронавируст халдварт (Ковид-19)-ын эмнэлзүйн болон стресс тайлах сургалтанд хамруулсан байна.

7.2. Мэргэшсэн хүний нөөц хязгаарлагдмал нөхцөлд ажиллуулах дэмжлэгт хүний нөөц

ТЭБ-д эмнэлгийн мэргэжилтний хүртээмж хязгаарлагдмал нөхцөлд эрүүл мэндийн суурь тусlamж, үйлчилгээ үзүүлэх чадавхитай эмнэлгийн бус ажилтнуудыг сургаж ажиллуулж болно. Үүнд:

7.2.1. Халдварт хамгааллын дэглэм, хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөж, тайлж сурсан байх;

7.2.2. Биеийн температур, зүрхний цохилт, амьсгалын тоо, цусны даралт зэрэг амин үзүүлэлтүүдийг хянах;

7.2.3. Пульсоксиметр ашиглаж хүчилтөрөгчийн сатурацийг хянах;

7.2.4. Шинж тэмдгийг бууруулах эмчилгээ буюу халуун бууруулах, хүйтэн жинтавих, хоол тэжээлийн ба шингэний талаархи зөвлөгөө өгөх;

7.2.5. Үйлчлүүлэгчийн биеийн байдал муудаж буй эсэхийг үнэлж чаддаг ба цаг алдалгүй эмнэлгийн мэргэжилтэнд мэдээлэл өгөх, үйлчлүүлэгчийн бусад эрүүл мэндийн байгууллага хооронд зөөвөрлөхөд эрүүл мэндийн ажилтанд дэмжлэг үзүүлж туслах;

7.2.6. Үйлчлүүлэгчийг сэтгэл зүйгээр дэмжих, эмнэлгийн мэргэжилтний зөвлөмжийн дагуу туслалцаа үзүүлэх.

Найм. Мэдээлэл, харилцаа холбоо ба нийгмийн оролцоо

8.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд нь үйлчлүүлэгчийн биеийн байдлын талаар өөрт нь болон ар гэрт нь мэдээлэл өгнө.

8.2. Үйлчлүүлэгчийн бүртгэл, мэдээлэл, тайлагналттай холбоотой журмуудыг хэрэгжүүлэн ажиллана.

8.3. Нутгийн захиргааны байгууллага болон бусад холбогдох байгууллагуудтай цаг үеийн мэдээллийг тухай бүрд солилицоно.

8.4. Шинээр ирсэн, гарсан, эмнэлэг хооронд шилжсэн хүний тоо, ор дүүргэлт, сул орны тоо, үйл ажиллагааны нөхцөл байдлын болон бусад мэдээллийг цаг хугацаанд нь холбогдох байгууллагад гаргаж өгнө.